

 ХБНГУ-ЫН ХОЛБООНЫ ЦАХИМ ХӨГЖИЛ, ТЭЭВРИЙН САЙД ФОЛЬКЕР
ВИССИНГИЙН АЙЛЧЛАЛ ХОЁР ДАХЬ ӨДРӨӨ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

- ✦ ХБНГУ-ын Холбооны цахим хөгжил, тээврийн сайд Фолькер Виссинг өнөөдөр /2024.03.06/ Монгол Улс-Холбооны Бүгд найрамдах Герман Улс хоорондын бизнесийн уулзалт, хэлэлцүүлэгт оролцож байна.
- ✦ Монгол Улсын Засгийн газраас 2024 оныг Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил болгон зарласантай уялдуулж, Зам, тээврийн хөгжлийн яам Бүсчилсэн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын жил болгон зорилт дэвшүүлээд байна.
- ✦ Авто замын салбарт хилийн боомт чиглэсэн, аймгийн төвүүдийг хооронд нь холбох, сумдыг холбох хатуу хучилттай авто замыг барьж байгуулна.
- ✦ Төмөр замын салбарт баруун болон зүүн чиглэлд нийт 1826 км төмөр замын барилгын ажлыг эхлүүлнэ гэдгийг дэд сайд Л.Халтар хэллээ.
- ✦ Хурлаар хоёр улсын гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны туршлага, цаашид нэмэгдүүлэх боломж, Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин, Германы хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын стратеги сэдвийн хүрээнд санал солилцлоо.
- ✦ Хамтын ажиллагааны хүрээнд дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулах, төсөл хэрэгжүүлэхэд төрийн байгууллагууд хүнд сурталгүй байх, хувийн хэвшлийнхийг хохироохгүй байх эрхзүйн боломжтой байх чухал гэдгийг ХБНГУ-ын хувийн хэвшлийн төлөөллүүд онцолж байна.
- ✦ Хоёр улсын тээврийн салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд харилцан санал солилцлоо.